



Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны 2012 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцэж батлав.

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ӨС ЗҮЙН ХЯНАЛТЫН ХОРООНЫ ЦАХИМ ХУУДАС АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмаар Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо (цаашид "Хороо" гэх)-ны цахим хуудсыг ажиллуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Хорооны <http://ethics.moh.mn> цахим хуудасны мэдээллийг тогтмол шинэчлэн баяжуулах, байнгын үйл ажиллагаатай байлгах, хороо болон Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо (цаашид „Салбар хороо” гэх), Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хороо (цаашид „Хэсгийн хороо” гэх)-ны үйл ажиллагааг эмнэлгийн мэргэжилтэн, олон нийтэд сурталчлах, лавлагаа мэдээллээр хангах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангахад энэхүү журмын зорилго оршино.

1.3 Цахим хуудас нь Эрүүл мэндийн яамны цахим хуудасны салшгүй хэсэг байх ба англи хэл дээрх хувилбартай байж болно.

1.4 Цахим хуудсыг ажиллуулахад Эрүүл мэндийн яам, Мэдээлэл, харилцаа, холбоо, технологийн газраас гаргасан журам, чиглэлийг баримтална.

Хоёр. Цахим хуудасны агуулга

2.1 Цахим хуудасны мэдээллийн агуулга нь Хороо, Салбар хороо, Хэсгийн хорооны дүрэм, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний агуулгад нийцсэн байна.

2.2 Цахим хуудас нь дараах үндсэн агуулгатай байна. Үүнд:

2.2.1 Мэндчилгээ

2.2.2 Эрхэм зорилго, чиг үүрэг

2.2.3 Хороо, Салбар хороо, Хэсгийн хорооны бүтэц, гишүүдийн талаарх мэдээлэл

2.2.4 Түүхэн хуудас

2.2.5 Хууль эрх зүйн актууд

2.2.6 Төлөвлөгөө, тайлан

2.2.7 Үйл явдлын мэдээ

2.2.8 Ярилцлага, хэлсэн үг

2.2.9 Статистик мэдээлэл

2.2.10 Асуулт хариулт

2.2.11 Өргөдөл гомдол

2.2.12 Ном товхимол

2.2.13 Оюутны булан

2.3 Цахим хуудасны ерөнхий дизайн, бүтэц, агуулгыг Хорооны хурлаар хэлэлцүүлж, гишүүдийн санал, зөвлөмжийг үндэслэн шинэчлэн өөрчилж болно.

Гурав. Мэдээлэлд тавигдах шаардлага

3.1 Хорооны цахим хуудаст тавигдах мэдээлэлд дараах үндсэн шаардлага тавигдана. Үүнд:

- 3.1.1 Цахим хуудаст байршуулах мэдээллийг Arial (Unicode) үсгийн фонтоор бичих;
- 3.1.2 Бодит, үнэн зөв байх;
- 3.1.3 Шуурхай байх;
- 3.1.4 Монгол хэлний зөв бичих дүрмийн дагуу бичих;
- 3.1.5 Гадаад нэр томъёо аль болох хэрэглэхгүй байх;
- 3.1.6 Хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл, зургийг зөвшөөрөлгүй байрлуулахгүй байх.

Дөрөв. Цахим хуудсыг ажиллуулах

4.1 Хороо нь цахим хуудсыг ажиллуулах, үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг удирдан зохион байгуулна.

4.2 Цахим хуудасны мэдээллийг Хороо, Салбар хороо, Хэсгийн хорооны нарийн бичгийн дарга нар дараах байдлаар шинэчлэн боловсруулж, баяжуулна. Үүнд:

4.2.1 Хорооны нарийн бичгийн дарга нь:

4.2.1.1 Мэндчилгээ, түүхэн замнал, төлөвлөгөө, статистик мэдээллийг жил тутамд;

4.2.1.2 Хороо, салбар хороо, хэсгийн хорооны нэгдсэн тайланг хагас жил тутамд;

4.2.1.3 Бүтцийн мэдээллийг шинэчлэгдэх бүрт;

4.2.1.4 Хууль эрх зүйн актууд, үйл явдлын мэдээ, оюутны булан, ном товхимлыг тухай бүрт.

4.2.2 Салбар хороо, Хэсгийн хорооны нарийн бичгийн дарга нь:

4.2.2.1 Статистик мэдээллийг улирал тутамд;

4.2.2.2 Салбар хороо, хэсгийн хорооны тайланг хагас жил тутамд;

4.2.2.3 Бүтцийн мэдээллийг шинэчлэгдэх бүрт;

4.2.2.4 Үйл явдлын мэдээг тухай бүрт.

4.3 Тухайн боловсруулсан мэдээллийг Хэсгийн хорооны нарийн бичгийн дарга нь Хэсгийн хорооны даргаар хянуулж, баталгаажуулан Салбар хорооны нарийн бичгийн даргад цахим хэлбэрээр, Салбар хорооны нарийн бичгийн дарга нь Салбар хорооны даргаар хянуулж баталгаажуулан Хорооны нарийн бичгийн даргад цахим хэлбэрээр тухай бүр хүргүүлнэ.

4.4 Салбар хороо, Хэсгийн хорооноос ирүүлсэн мэдээлэл, Хорооны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулах ажлыг Хорооны нарийн бичгийн дарга буюу Эрүүл мэндийн яамны эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцан ажиллана.

4.5 Хорооны даргын шийдвэрээр цахим хуудсыг ажиллуулахтай холбоотойгоор Хорооны гишүүдийн ажил үүргийн чиг хуваарийг баталж болно.

4.6 Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн хэлтэс (цаашид "Ажлын алба" гэх) нь цахим хуудас

ажиллуулахтай холбоотой өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана.

4.7 Хорооны цахим хуудсыг боловсруулах, шинэчлэх, яамны цахим хуудаст холбоос байдлаар байршуулахад Эрүүл мэндийн яамны мэдээлэл, технологийн хөгжил хариуцсан мэргэжилтнээс тухай бүр мэргэжил арга зүйн дэмжлэг авч ажиллана.

Тав. Зар сурталчилгаа

5.1 Хорооны цахим хуудсанд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйтэй холбоотой сурталчилгааг үнэгүй байршуулна.

5.2 Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, төрийн бус байгууллага, төсөл, хөтөлбөрийн ашгийн бус үйл ажиллагааны зар сурталчилгааг гэрээ байгуулсны үндсэн дээр Хорооны цахим хуудсанд байршуулж болно.

5.3 Цахим хуудаснаас олсон орлогыг Хороо, Салбар хороо, Хэсгийн хорооны үйл ажиллагаанд зарцуулна.

---oOo---